



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/24

Баянтал сум

Архивт нэгдсэн тооллого явуулах
комиссыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаал "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 7.3, 7.4, дэхь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын архивын хадгаламжийн нэгжийн бодит тоог тогтоох, тоо бүртгэлийн баримт бичигт тусгагдсан тоототой тохирч буй эсэхийг шалгах, механик болон биологийн гэмтлээс урьдчилан сэргийлэх, сэлбэн засах шаардлагатай баримтыг илрүүлэх зорилгоор архивын баримтад тооллого явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ц.Булган (Хууль эрх зүй, дотоод
ажил хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Л.Отгонпүрэв (Санхүү албаны дарга)
М.Бодыгэрэл (Нийгмийн бодлого худалдан
 авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Х.Ариунгуа (Нягтлан бодогч)
Б.Солонгомаа (Нягтлан бодогч
Н.Сарантуяа (Нярав)
Б.Оюунцэцэг (Үйлчлэгч)
Ц.Болдбаатар (Жижүүр)
О.Бадамдорж (Жолооч)
Г.Ганзориг (Жолооч)

Нарийн бичиг:

Н.Мөнгөнцэцэг (Архив, бичиг хэргийн
эрхлэгч)

2. Байгууллагын Архивын баримтын нэгдсэн тооллогыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 08-ны дотор зохион байгуулсугай.

3. Тооллогыг тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бодитой, зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж акт үйлдэн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Ц.Булган) д даалгасугай.

ДАРГА



ШИНЭБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/25

Баянтал сум

Ахмадад хүндэтгэл үзүүлэх зардлыг
батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дүгээр зүйлийн 67.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Ахмадын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Байгууллагын ахмадын сангийн журмын 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Уламжлалт ахмадын баярыг тохиолдуулан тус байгууллагаас өндөр настны тэтгэврт гарсан 30 ахмадад хүндэтгэл үзүүлэх 3,000,000 (гурван сая) төгрөгийг нэгдүгээр хавсралтаар олгосугай.

2. Байгууллагын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх бусад зардал 300,000 (гурван зуу мянга) төгрөгийн зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Батлагдсан төсвөөрх 3,300,000 (гурван сая гурван зуу мянга) төгрөгийг ЗДТГ-ын ахмадын сангийн зардлаас гаргахыг Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ш.ШИНЭБАЯР


Засаг даргын Тамгын газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 22-ны
өдрийн 10 дугаар тушаалын
01 дүгээр хавсралт



Ахмадын нэрс

№	Овог нэр	Дансны дугаар	Регистерийн дугаар
1	Д.Цэндсүрэн	5994033346	ЗМ 32021901
2	Б.Бямба-очир	5990599519	ЕД 40121470
3	Х.Хоролсүрэн	5463024075	ЗН 45070129
4	Б.Дагдан	221500048225	ЗП 48052531
5	М.Доржхуяг	5463012060	ЗН 51010105
6	Л.Жаргалсайхан	5990379140	НШ 54031518
7	Л.Банди	5994014618	ЗМ 54011716
8	Д.Дуламсүрэн	5075372908	ЗН 55030802
9	Х.Үзмээ	5990302100	ЗН 57091902
10	Л.Лхагвасүрэн	5994005355	ЗЕ 58082618
11	Д.Шоовдор	5994007112	ЗЮ 58081560
12	С.Оюунчимэг	5990193280	ЕЙ 59080705
13	Ч.Бадамгарав	5994003355	ЗЕ 60081000
14	Л.Батнасан	5463001411	ЗН 61090214
15	Т.Арвай	105000175003	НЮ 62112297
16	П.Төмөрбаатар	5990653614	ТГ 62040514
17	С.Сувд	5994014222	ЗН 540872206
18	Д.Оюунгэрэл	5990184719	ШЖ 65090561
19	Н.Нарангэрэл	5994037454	ЕА 74091207
20	Ч.Ганзориг	5994039462	ЗЮ 65030512
21	Д.Мягмар	5994013943	ЗН 66060103
22	Р.Батчимэг	5994001198	ЗН 67031301
23	Б.Наранцэцэг	300100021320	ЕЙ 68091226
24	Э.Янжмаа	5994025212	ОК 69081905
25	С.Оюунтүлхүүр	5994036370	ШЖ 69111160
26	Ч.Чулуунтогтох	5994017377	ЕВ 61020304
27	В.Гантуяа	5994004542	ЗЮ 71040506
28	Д.Доржпүрэв	5991122026	СЛ 62090512
29	М.Бямбасүрэн	5463008881	ЗН 56011516
30	М.Батсуурь	5991033677	ЗН58031015

Засаг даргын Тамгын газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 02-ны
өдрийн 102 дугаар тушаалын
02 дугаар хавсралт



Баянтал сумын ахмад настангуудад хүндэтгэл
үзүүлэх махны төсөв

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бусад зардал	кг	21,42	14,000	300,000
					300,000

Төсвийн тооцоолол гаргасан нярав

Н.Сарантуяа



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/26

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Удирдлагын академи боловсролын төрийн удирдлагын үйлчилгээ удирдах ажилтны багц сургалтанд Тамгын газрын дарга Ш.Шинэбаяр сургалтанд хамрагдах тул зардалд 1,755.000 (нэг сая долоон зуун тавин таван) мянган төгрөгийг зарцуулсугай.

2. Засаг даргын Тамгын газрын Хичээл үйлдвэрлэл дадлага хийх зардлаас гаргахыг Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Ш.ШИНЭБАЯР





مهر و مهره نام مهر

[illegible]



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 127

Баянтал сум

Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ни өдрийн “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 208 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Төсөв төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг “Алсын хараа 2025” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, “Төрийн албаны тухай хууль”, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Ц.Булган)-д үүрэг болгосугай

ДАРГА

Ш.ШИНЭБАЯР





МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Засгийн газрын XI байр, Сэмбүүгийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 42 16 Факс: 1976-51126 44 60
Цахим шуудан: info@csc.gov.mn
Цахим хуудас: www.csc.gov.mn

2025.07.24 № 06/1647

танай _____ -ны № _____ -д

Тогтоол хүргүүлэх тухай

Сумын Засаг даргын Тамгын газрын нийтлэгээр батлан мөрдөх удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл олгосон Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 208 дугаар тогтоолыг хавсралтын хамт хүргүүлэв.

Батлах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг сумын Засаг даргын Тамгын газрын батлагдсан бүтэц, орон тооны шийдвэрт нийцүүлэн, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталж, мөрдүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар ханган ажиллаж, баталсан шийдвэрийг нэгтгэн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



В.ЖАВЗАН

4

1525073354



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралт ёсоор шинэчлэн батлахыг сумын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

2.Сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар хавсралт ёсоор шинэчлэн батлахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

3.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга нарт даалгасугай.

4.Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хангаж, эрх зүйн байдлыг дордуулахгүй байх арга хэмжээ авахыг сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга нарт зөвлөсүгэй.

5.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (В.Жавзан)-д даалгасугай.


6.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн "Зөвшөөрөл олгох тухай" 2019 оны 42 дугаар тогтоол, 40 дүгээр тогтоолын 1, 2, 4, 7 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Л.ЦЭДЭВСҮРЭН

1525510852

המחבר



המחבר

המחבר

המחבר

המחבר

המחבר

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
208 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

ТА аймгийн Балстас сумын
Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Засаг даргын Тамгын газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

ТА, Балстас сум, ЗТТ байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, орон нутгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих, Засаг даргад бодлогын зөвлөгөө, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах, тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих.
- 2.Орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах.
- 3.Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.
- 4.Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах, хяналт тавих.
- 5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах;	Бодлогын баримт бичиг, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлт хангагдсан байна.	Х.Г
	2.Бодлогын баримт бичиг хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжүүлэх, тайлах, хянах;	Хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Х.Г
	3.Орон нутгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах;	Хуульд заасан 4 төрлийн мэдээллийг нийтэд мэдээлсэн байна.	Х.Г
	4.Хугацаатай мэдээ, тайлан, судалгааг нэгтгэн, хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцон тайлагнах;	Хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. Тайлан үнэн зөв гарсан байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Сайдын тушаал, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайд, аймаг, сумын Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд	Хууль тогтоомж, шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х

	нэгдсэн удирдлагаар хангах, явц биелэлтэд хяналт тавих;		
	2.Үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан хаагчдыг бодлогын удирдамжаар хангах, холбогдох дээд шатны байгууллагад тайлагнах;	Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнд хүрсэн байна.	Г, Х
	3.Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр хангах;	Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмжөөр хангасан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.	Х, Ш
	2.Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;	Төрийн албан хаагчдын мэргэшил, чадавхажсан байна.	Х, Ш
	3.Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, албан бичгийн стандартыг мөрдөж албан хэрэг хөтлөлтөд үүссэн баримт бичгийн бүрдүүлэлт эмх цэгцийг хариуцан хадгаламжийн нэгж бүрдүүлж архивд шилжүүлэх;	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэж ажиллах, эргэн мэдээлэх;	Хэрэгжилтийг хуулийн хүрээнд хангасан байна.	Г
	5.Төрийн албан хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар гарсан бодлого шийдвэр, хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах;	Байгууллагын дотоод хэм хэмжээ, холбогдох ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах;	Тогтоол, шийдвэр, дүрэм, журам, стандартыг	Г

		хэрэгжүүлэн ажилласан байна.	
	7.Байгууллагын төлөвлөгөөний хангах, тайлагнах;	гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна.	Г
	8.Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох;	Идэвх санаачилгатай ажилласан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, биелэлтийг хангах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г, Х
	2.Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах, үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлж, төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, цалинтай холбогдох асуудлыг холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х, Ш
	3.Төсвийн шууд захирагчийн хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх, төсвийн төсөл, төлөвлөлтийг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	4.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнасан байна.	Г
	5.Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Дотоод хяналтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийсэн байна.	Г, Х
	6.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэд хяналт тавьж балансад байгаа өмч хөрөнгийг зохих журмын дагуу эзэмшиж ашиглах;	Өмчийн бүрэн бүтэн байдал хангагдсан байна.	Г, Х
	7.Төсөв санхүүгийн болон худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;	Хуульд заасны дагуу хэрэгжилт хангагдсан байна.	Г
	8.Сумын хэмжээний статистик бүртгэл, тооллого, судалгаа	Статистик бүртгэл, судалгаа мэдээллийн үйлчилгээг	Г

	мэдээллийн үйлчилгээг удирдлага зохицуулалтаар хангаж, хянах;	удирдлага зохицуулалтаар хангасан байна.	
	9.Тамгын газрын архив, бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг хууль тогтоомж, стандартын дагуу зохион байгуулах;	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны стандарт хангагдсан байна.	Г
	10.Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	11.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллагын үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлэх, хяналт тавих;	Ил тод байдлын шалгуур, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Х, Ш
5 дугаар зорилтын хүрээнд	1.Сумын Засаг дарга, түүний Тамгын газрын төрийн нууцын асуудлыг хариуцан ажиллах;	Төрийн болон албаны нууцын тухай хууль хэрэгжсэн байна.	Г
	2.Сумын "Улсын дайчилгааны төлөвлөгөө", "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө" "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;	Батлан хамгаалах болон онцгой байдлын арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна.	Х, Г
	3.Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангах ажлыг хариуцаж, бодлого зохицуулалтаар хангах;	Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт нутаг дэвсгэрийн хэмжээнд хангагдсан байна.	Г
	4.Сумын хэмжээнд нотариатын үйлчилгээг хууль, журмын дагуу хүргэх, хууль, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Хууль, журмын дагуу зөрчил, гомдол гараагүй байна.	Г
	5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж, тайлагнах	Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт нутаг дэвсгэрийн хэмжээнд хангагдсан байна.	Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		

Мэргэжил	-Эрх зүй (042); -Нягтлан бодох бүртгэл, татвар (0411); -Эдийн засаг (0311); -Бусад.	
Мэргэшил	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	-Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх; -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- төрийн албаны бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг хариуцлага хүлээх; - төрийн албаны хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; - нэгжийн албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах; - нэгжийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, туршлагыг бүрэн дайчлах, тодорхой чиглэлээр мэргэшихийг дэмжих; - нэгжийн албан хаагчдын санал, бодлыг нь сонсох, эргэх холбоотой байх; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	- Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх. - Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх. - Мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгаа хийх.
	Асуудал шийдвэрлэх	- Хуульд нийцсэн шийдвэр гаргах; - Оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; - Аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль, тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах; - Албан тушаалын бүрэн эрхийн хүрээг баримталж шийдвэр гаргах; - Гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх - Бусад
	Манлайлах	- ажил хэргийн хувьд зарчимч, бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - төрийн албаны болон байгууллагын шинэчлэлт, өөрчлөлтийг манлайлах; - нэгжийн албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, үлгэрлэн манлайлах; - нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - бусад.

	Бусад	- Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах - Багаар ажиллах чадвартай байх - Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх - Гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай - Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах - Бусад ур чадвар
--	-------	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:


Сумын Засаг дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> - Мэргэжилтэн - Төрийн үйлчилгээний албан хаагч - Багийн Засаг дарга Нийт	<u>Бусад харилцах субъект</u> 1. Сумын Засаг даргын орлогч 2. Аймгийн Засаг даргын Тамгын газар 3. Аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс 4. Сумын төсөвт байгууллагууд 5. Иргэн, хуулийн этгээд
--	--

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> <u>Албан тушаал:</u> ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН <i>Ц.З.М.С.</i> (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ...-ны өдөр	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> <u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> ... <u>Дугаар:</u> ...
--	--

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

<u>Байгууллагын нэр:</u> <i>Балсан</i> СУМЫН ЗАСАГ ДАРГА <u>Шийдвэрийн огноо:</u> 2025.10.13 <u>Дугаар:</u> (тамга/тэмдэг) ЗАСАГ ДАРГА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ...-ны өдөр	
---	--

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
208 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

НТ аймгийн *Балцор*
сумын Засаг даргын Тамгын газар

Албан тушаалын нэр:

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-8

Ажлын байрны албан ёсны байршил:

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нутаг дэвсгэрийн хэмжээнд төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн байгууллагуудад төрийн сангийн үйлчилгээ үзүүлэх, статистик мэдээллийг хариуцан ажиллаж, ажлын гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг даргын Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.

Албан тушаалын зорилт:

- 1.Төсвийн байгууллагын төлбөр тооцоог холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд системд бүртгэж тайлагнах;
- 2.Санхүү, төсвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актыг судлан төсвийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй нэгжийн санхүүгийн тайланг хүлээж авах, хяналт тавих;
- 3.Төсвийн ил тод нээлттэй байдлыг хангуулах;
- 4.Сумын статистик мэдээллийн нэгтгэлийг холбогдох тасаг, нэгж албан тушаалтнаас ирүүлсэн мэдээнд үндэслэн сангийн сайд, үндэсний статистикийн газрын даргын хамтарсан тушаалын дагуу боловсруулж холбогдох байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх;
- 5.Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн орон нутагт хамааралтай зорилтуудыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах;	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Г
	2.Сумын төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог батлагдсан төсвийн хуваарь, төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн системд бүртгэж, төрийн сангийн өдөр тутмын мемориалын баримтыг тулган, архивын нэгж үүсгэх;	Санхүүгийн үйл ажиллагааг хуульд тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн байна.	Г
	3.Төсвийн байгууллагуудаас гарын үсгийн баталгааг холбогдох журмын дагуу хүлээн авах, хянах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, журмыг судлан, аж ахуй нэгж байгууллагад өөрчлөлтийн талаар тухай бүр мэдээлэл өгөх, сурталчлах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн мэдээллээр хангасан байна.	Г

	2.Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд цахимаар илгээж байгаа эсэхэд хяналт тавих, тайланг нэгтгэх;	Санхүүгийн тайлан хуулийн хугацаанд, стандартын дагуу илгээгдсэн байна.	Т, Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах, удирдлагаар батлуулж ажиллах;	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Төсвийн мэдээллийг ил, тод байдлаар боловсруулж, мэдээллийн самбарт төсвийн байгууллага бүрээр мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулах	Мэдээллийг цаг тухайд нь байршуулсан байна.	Г
	3.Харьяа байгууллагуудын өр, авлагын болон арилжааны банкны дансны үлдэгдлийн сарын мэдээг нэгтгэн боловсруулах, удирдлагад танилцуулах, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэст дараа сарын 4-ний дотор хүргүүлсэн байна.	Г
	4.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн Дотоод аудитыг хэрэгжүүлж дээд шатны байгууллагатай хамтран ажиллах	Хууль журмын хэрэгжилт хангагдаж, эрсдэлийн хэмжээ буурсан байна	Т
	5.Татварын орлогыг хууль тогтоомж, шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулахад Татварын албатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;	Орон нутгийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.	Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Сумын статистик мэдээ тайлан, тооллого судалгаа, мэдээллийн санг хөтөлж, тайлан мэдээллийг гаргах,	Мэдээ, тайланг статистикийн хэлтэст цаг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Г
	2.Сумын статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангаж, мэдээ, мэдээллээр холбогдох албан тушаалтан, байгууллага, иргэнийг хангах,	Мэдээ, тайлан үнэн зөв байна. Шаардлагатай мэдээ мэдээллээр тухай бүр хангаж ажилласан байна.	Г
	1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг	Г

5 дугаар зорилтын хүрээнд	дүрэм, журмыг боловсруулахад оролцох, дүрэм, журам, заавар, стандартуудыг мөрдөж ажиллах	мөрдөн ажиллах	
	2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн сургалт, зөвлөгөөнд идэвхтэй оролцох, осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах	Г
	3.Холбогдох хуульд тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан байна.	Г
	4.Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх;	Зөрчил дутагдалгүй ажилласан байна.	Г
	5.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх;	Хэрэгжилтийг хуулийн хүрээнд хангасан байна.	Г
	6.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх;	Ёс зүйн зөрчил гаргаагүй, иргэдээс гомдол гаргаагүй байна.	Г
	7.Хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах;	Хуулийн хугацаанд үнэн зөв гаргасан байна.	Г
	8.Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.	Г
	9.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг албан бичиг боловсруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах;	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Г
	10.Өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гарган холбогдох мэргэжилтэнд өгөх;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан байна.	Г

	11.Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох;	Идэвх санаачилгатай оролцсон байна.	Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	- Нягтлан бодох бүртгэл,татвар (0411); - Санхүү, банк, даатгал (0412); - Эдийн засаг (0311); - Бизнесийн удирдлага (041301);		
Мэргэшил	- Шаардахгүй		
Туршлага	- Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн ерөнхий мэдлэгтэй байх; - өгөгдлийг цуглуулж, боловсруулалт, дүн шинжилгээ хийх; - тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх; - судалгааны үр дүнд үндэслэн урьдчилан таамаглал дэвшүүлж, болзошгүй эрсдэлийг даван туулах, төлөвлөгөө боловсруулах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг боловсруулах; - мэдээллийн уялдаа холбоо чиг хандлагыг олж харж чаддаг байх; - мэдээллийг түргэн шуурхай, үр дүнтэй байдлаар нягтлан судалж, нэмэлт мэдээлэл шаардлагатай эсэхийг тодорхойлдог байх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- аливаа асуудлыг албан тушаалын чиг үүргийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - бусад.	
	Багаар ажиллах	- ажил хэргийн хувьд зарчимч, бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - төрийн албаны болон байгууллагын шинэчлэлт, өөрчлөлтийг манлайлах; - бусдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, үлгэрлэн манлайлах; - нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - бусад.	
	Бусад	- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт техник, технологи ашиглах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд санаачилгатай ханддаг байх; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх;	

- төрийн болон хувь хүний нууцыг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Засаг даргын Тамгын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтнүүд;
2. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын дарга, мэргэжилтнүүд;
3. Сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд;
4. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ажлын алба;
5. Багийн Засаг дарга, багийн зохион байгуулагч;
6. Төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

Балсан

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
208 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

..... аймгийн сумын
Засаг даргын Тамгын газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-9

/Улсын байцаагчийн эрхтэй бол ТЗ-7/

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгаль орчны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг даргын Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.

Албан тушаалын зорилт:

- 1.Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийг орон нутагт зохион байгуулах, биелэлтийг хангах;
- 2.Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах;
/Эрх бүхий байгууллагаас олгосон улсын байцаагчийн эрхтэй бол дээр чиг үүргийг хэрэгжүүлэх/
- 3.Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахад төр, иргэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг уялдуулан, арга зүй удирдлагаар хангаж ажиллах;
- 4.Бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, улсын эдийн Засаг нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэлийн орон нутагт хамааралтай зорилтуудыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах;	Хууль тогтоомж шийдвэр үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна	Г, Х
	2.Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмыг чанд сахин биелүүлэх;	Хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	Х, Г
	3.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах;	Хяналт шалгалт хуулийн дагуу хийгдсэн байна.	Г
	4.Хууль тогтоомж зөрчиж, байгаль орчинд хохирол учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын лиценз, зөвшөөрөл, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр болон бүр мөсөн зогсоох саналаа тухайн эрх	Хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоож, зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.	Г

	олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;		
	5.Байгаль орчны тухай хууль тогтоомж зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх;	Хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хууль тогтоомж, стандарт зөвшөөрөгдөх хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг уг зөрчил арилгахыг шаардах, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг зогсоох;	Хууль тогтоомж, стандартыг иргэн, хуулийн этгээдэд мөрдүүлсэн байна.	Х, Г
	2.Хяналт шалгалтад шаардагдах бичиг баримт, бусад мэдээ баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулж, нэгтгэх, дүгнэлт хийх;	Мэдээ, тайланг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн байна.	Г
	3.Хяналт шалгалтад шаардагдах бичиг баримт, бусад мэдээ баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулж, нэгтгэх, дүгнэлт хийх;	Сорьц дээжийг стандартын дагуу хийгдсэн байна.	Х,Г
	4.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцад тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон, байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хурааж, Зөрчлийн тухай хууль зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах;	Чиг үүргийн хүрээнд холбогдох арга хэмжээ авсан байна.	Х,Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, хамтран ажиллах;	Иргэн, хуулийн этгээдийн оролцоо нэмэгдсэн байна.	Г

	2.Байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг тооцож удирдлагуудад танилцуулах;	Байгаль хамгаалагчийн ажлын үзүүлэлт дээшилсэн байна.	Г
	3.Байгаль орчны чиглэлийн эрх зүйн болон бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг хангах чиглэлээр байгаль хамгаалагчийн ажлыг чиглүүлэх;	Байгаль хамгаалагчийн ажлын үзүүлэлт дээшилсэн байна.	Х, Г
	4.Байгалийн баялаг ашиглахтай холбогдсон иргэдийн мэдээ, мэдээллийн дагуу шалгалт хийх, холбогдох арга хэмжээ авах;	Тайлбар, лавлагаа, зөвлөмж нь хуульд нийцсэн байх, мэдээлэл бодитой байна.	Х, Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох, дүрэм, журам, заавар, стандартуудыг мөрдөж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг мөрдөн ажиллах	Г
	2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн сургалт, зөвлөгөөнд идэвхтэй оролцох, осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах	Г
	3.Гамшгаас хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангахад удирдлагад дэмжлэг үзүүлж, зохицуулалтаар хангах, хуульд тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд ханган ажилласан байна.	Г
	4.Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх;	Зөрчил дутагдалгүй ажилласан байна.	Г
	5.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал,	Ёс зүйн зөрчил гаргаагүй, иргэдээс	Г

эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх;	гомдол гаргаагүй байна.	
6.Хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах;	Хуулийн хугацаанд үнэн зөв гаргасан байна.	Г
7.Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.	Г
8.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг албан бичиг боловсруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах;	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Г
9.Өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гарган холбогдох мэргэжилтэнд өгөх;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан байна.	Г
10.Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох;	Идэвх санаачилгатай ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	- Эрх зүй (0421), - Байгалийн шинжлэх ухаан (053), - Ойн аж ахуй (082), - Хүрээлэн буй орчин (052), - Хүрээлэн буй орчныг хамгаалах технологи (0712), - Уул уурхай олборлолт (0724) - Хөдөө аж ахуй/081112-081113.081202/	
Мэргэшил	Шаардахгүй.	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн ерөнхий мэдлэгтэй байх; - өгөгдлийг цуглуулж, боловсруулалт, дүн шинжилгээ хийх; - тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх; - судалгааны үр дүнд үндэслэн урьдчилан таамаглал дэвшүүлж, болзошгүй эрсдэлийг даван туулах, төлөвлөгөө боловсруулах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг боловсруулах; - мэдээллийн уялдаа холбоо чиг хандлагыг олж харж чаддаг байх; - мэдээллийг түргэн шуурхай, үр дүнтэй байдлаар нягтлан судалж, нэмэлт мэдээлэл шаардлагатай эсэхийг тодорхойлдог байх; - бусад.

Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	- аливаа асуудлыг албан тушаалын чиг үүргийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - бусад.
	Багаар ажиллах	- ажил хэргийн хувьд зарчимч, бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - төрийн албаны болон байгууллагын шинэчлэлт, өөрчлөлтийг манлайлах; - бусдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, үлгэрлэн манлайлах; - нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - бусад.
	Бусад	- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт техник, технологи ашиглах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд санаачилгатай ханддаг байх; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - төрийн болон хувь хүний нууцыг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Засаг даргын Тамгын газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>
	1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтнүүд; 2.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын дарга, мэргэжилтнүүд; 3.Сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд; 4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ажлын алба; 5.Багийн Засаг дарга, багийн зохион байгуулагч; 6.Төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
---	--

Албан тушаал:

ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр,
өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны
өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

Сумын Засаг даргын Тамгын Газар

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

(Гарын үсэг) (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
208 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

ГА аймгийн Балстас
сумын Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Санхүүгийн албаны дарга буюу
төсвийн ерөнхий нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, сумын төсөвт байгууллагын төсвийн орлого, зарцуулалтын үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, удирдлагад мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж, бодит мэдээ, мэдээллээр хангах, чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг сумын Засаг даргын өмнө хариуцан тайлагнана.

Албан тушаалын зорилт:

1.Сумын санхүүгийн албаны үндсэн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, санхүү эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагаа, зээл тусламжийн хэрэгжилт, орон нутгийн өмч хөрөнгө, төсвийн тодотголын төслийг боловсруулан хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэн тайлагнах.

2.Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газар болон аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, төсвийн менежерүүд, бусад албан хаагчдыг мэдээллээр хангах.


3.Сумын татварын орлогын төлөвлөгөөг хянан гүйцэтгэлийг хангуулж, орон нутгийн байгууллагуудын санхүүжилтийг батлагдсан төсөвт багтаан хуваарилж, зарцуулалтыг хянан баталгаажуулах.

4.Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах.

